

орчуулагч, сэтгүүлч, олон нийтийн томоохон зүтгэлтэн Цэндийн Дамдинсүрэнгийн эрдэм шинжилгээний бүтээл туурвилдаа баримталж ирсэн өндөр шаардлага, нөр их хөдөлмөр, нягт нямбай чанар нь нийт бичгийн сэхээтний өвлөн авч эзэмшвэл зохих жишээ юм.

Д. Энхтайван

1. «Хөдөлмөр» 1988. IX. 13 (Ц. Дамдинсүрэн миний гурван үеийн намтар)
2. Ц. Дамдинсүрэн «Гэсэрийн туужийн гурван шинж» УБ., 1956 он
3. Harvard. Journal of Asiatie studies vol 21

## ТЭМЦЛИЙН ЗАМ

(Пэн Дэхуайн мэндэлсний 90 жилийн ойд)

Л. БЭГЗЖАВ

Эхээсээ өнчрөн үлдсэн бяцхан Дэхуай (1898-1974) яхир хатуу хойт эхээсээ залхан, 9 настайдаа төрсөн гэрээсээ зугатан явж зовлон зүдгүүрт амьдрал үзжээ. Пэн Дэхуай балчир насны хирээс хэтэрсэн хүнд ажилд нухлагдан, мал хариулж, үүрийн гэгээнээс үдэш орой болтол бүхэл өдөржингөө нүүрсний уурхайд ажиллаж, мөн гуталчин, чулуучин зэрэг хар бор ажил хийн амь зууж явсан байна.<sup>1</sup> 18 нас хүрмэгц төрсөн нутаг Хунань мужид цэргийн алба хаах болсноор Пэн дэхуайн армийн амьдрал эхэлжээ. Тэрээр Хунаны офицерын сургууль төгсөж, Сунь Ят сений Үндэсний хувьсгалт армид ротын захирагч, улмаар батальон, хорооны захирагч хүртэл алба хаажээ.

Сунь Ятсенийг нас барсны дараа Чан Кайши үндэсний хувьсгалт армийн удирдлагыг авч, гадаадын империализм дотоодын харгис хүчинтэй эвсэн хуйвалдсанаар империализм феодализмыг эсэргүүцсэн 1925—1927 оны хятадын хувьсгал ялагдсан билээ. Энэ үеэс Пэн Дэхуай эх орныхоо эрх чөлөө, ард түмнийхээ зол жаргалант ирээдүйн төлөө тэмцэлд бүхий л амьдралаа зориулахаар санаа шуудран ХКН-д элссэн нь түүний амьдралын цоо шинэ, хүнд бэрх, дайчин замналын эхлэл болжээ.

1928 оны 4-р сард ХКН-д гишүүнээр элссэн тухайгаа Пэн Дэхуай хожим дурсан бичихдээ: «Тэр орой би намд элсэхдээ тангараг өргөв. Ёслол сүрлэг сайхан болсон. Хананд К. Маркс, Ф. Энгельс нарын хөргийг байрлуулж, даавуун дээр «Орон бүхний пролетари нар нэгдэж, коммунист нийгмийн төлөө тэмцэгтүн!» гэж бичсэн байлаа. Би Хятадын ба дэлхийн хувьсгалын үйл хэргийн төлөө, коммунизмын үйл хэргийн төлөө өөртөө байгаа бүхнээ, хэрэгцээ тохиолдвол амьдралаа ч зориулна гэж андгайлсан юм. Энэ ёслол гүн сэтгэгдэл төрүүлж билээ»<sup>2</sup> гэж бичсэн байна.

Пэн дэхуай Хятадын хувьсгалын ялагдал, ялалтын жилүүд, тэмцэл тулалдааны шуурган галын дунд ч, БНХАУ-ын социалист байгуулалтын төлөө тэмцэлд ч өргөсөн тангарагтаа үнэнч явж, «ёстой байлдагч бөгөөд коммунист нэрийг авч явж чадах хүн»<sup>3</sup> гэдгээ нам, ард түмэндээ нэр төртэй харуулсан юм. 1928 оны 7-р сард Хунань мужийн Пинзян хошуунд гарсан тариачны хөдөлгөөнийг даруулахаар Чан Кайши Үндэсний хувьсгалт армийн нэгэн дивизийг илгээжээ. Энэ дивизийн бүрэлдэхүүнд явсан Пэн Дэхуай гоминданы харгис хүч, империалист ноёрхлын эсрэг тэмцэхээр шийдэж бослого гаргажээ. Бослогод оролцогчдод хандан Пэн Дэхуай улс орныхоо үндэсний болон нийгмийн эрх чөлөөний төлөө, ажилчин тариачны эрх ашгийн төлөө амь хайргүй тэмцэхийг уриалсан байна. Бослого амжилттай болж, Пинзян хошуунд ажилчин тариачны Зөвлөлт засаг тогтож, хятадын ажилчин тариачны улаан армийн 2 дугаар Корпус байгуулагджээ. Уг корпусын командлагчаар сонгогдсон Пэн Дэхуайг «Пинзян хошууны хүн ард авран хамгаалагчаа»<sup>4</sup> гэж үзэж байжээ.

Хятадад ноёрхож байсан гоминданы харгислалын эсрэг тэмцлийн жилүүдэд Пэн Дэхуайн авьяас билэг, цэргийн эрдэмд гарамгай, асар их туршлагатай болох нь улам бүр тодорчээ. Тэрээр нам, командлалаас өгсөн хамгийн хариуцлагатай, аюул сөрсөн даалгаврыг нэр төртэй биелүүлж, эрэлхэг зориг, эрдэм чадлаараа гайхагдаж байв. Түүний нэр ХКН ХАЧА-ийн дотор хүндтэй байр эзлэх болж, ард түмний дунд бараг домог болон түгсэн байна. Японыг эсэргүүцсэн дайны (1937—1945) жилүүдэд Пэн Дэхуай олон удаагийн тулалдаанд гарамгай оролцож, дайсны ар талд японыг эсэргүүцсэн бааз байгуулах, ардын зэвсэгт хүчийг зохион байгуулах их ажил хийжээ.

Хятадын ард түмний олон жилийн баатарлаг тэмцэл, ЗХУ-ын асар их тусламжийн үрээр 1949 онд Хятадад ардын ардчилсан хувьсгал ялж, Хятадын ард түмний түүхэн шинэ үе эхэлсэн. Энэ ялалтанд хятадын хувьсгалын баатар гэж зүй ёсоор нэрлэгддэг Пэн Дэхуайн оруулсан хувь нэмэр багагүй. Нам, ард түмэн нь түүнд өндөр итгэл хүлээлгэн, нам төрийн хариуцлагатай албанд удаа дараа томилон ажиллуулж байв. Пэн Дэхуай ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүнээр удаа дараа сонгогдож, 1954—1959 онд БНХАУ-ын БХЯ-ны сайд, мөн Төрийн зөвлөлийн ерөнхий сайдын орлогч, Улсын батлан хамгаалах хорооны орлогч даргаар хавсран ажиллаж байлаа.

Пэн Дэхуай бол улс түмний найрамдал, хамтын ажиллагаа, ялангуяа ЗХУ, социалист бусад оронтой хятадын тогтоосон найрамдалт харилцааг гүнээ хүндэтгэн үзэж хөгжүүлэн бэхжүүлэхийн төлөө тэмцдэг хүн байлаа. Тэрээр ЗХУ-д хэд хэдэн удаа, дорнод европын социалист орнууд, мөн манай оронд айлчилсан юм. 1957 онд ХАЧА байгуулагдсаны 30 жилийн ойн баярын хурал дээр Пэн Дэхуай: «Даян дэлхийд өнө бат энх тайван тогтоох найдвартай баталгаа болж буй ЗХУ, социалист бусад бүх орны бат нягт эв нэгдлийг бид цаг ямагт сахин хамгаалах болно»<sup>5</sup> гэж тэмдэглэж байлаа. Пэн Дэхуайг сайн мэдэх БНАГУ-ын хятад судлаач О. Браун бичихдээ: «түүнтэй хэд хэдэн удаа ярилцахад тэрээр жинхэнэ интернационалч, ЗХУ-ын үнэнч анд нөхөр болох нь мэдэгдэж билээ»<sup>6</sup> гэжээ. 1950—1953 онд Солонгосын эсрэг АНУ-ын өдүүлсэн дайнд Пэн Дэхуай хятадын сайн дурынханыг командлан оролцож, АНУ-ын түрэмгийллийн эсрэг баатарлаг тэмцэж байлаа. Түүний гавьяаг Солонгосын ард түмэн өндөр үнэлж, БНАСАУ-ын баатар цол, Солонгосын тугийн одонгийн нэгдүгээр зэргээр шагнажээ.

Хятадын ард түмний үнэнч хүү Пэн Дэхуайг монголын ард түмэн сайн мэднэ. БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайдын орлогч, БХЯ-ны сайд маршал Пэн Дэхуай БНХАУ-ын цэргийн төлөөлөгчдийг тэргүүлэн БНМАУ-ын Цэргийн ба нийгмийг аюулаас хамгаалах Яамны урилгаар 1959 оны 6-р сарын 6-13-нд манай оронд айлчилсан билээ. Маршал Пэн Дэхуай манай оронд айлчлах хугацаандаа цэргийн анги, үйлдвэр, сангийн аж ахуй, урлаг соёлын газруудаар орж, монголын ард түмний социалист байгуулалтын ололт амжилттай танилцсан байна. Тэрээр монгол, Хятадын ард түмний найрамдал, монголын ард түмний амжилт ололт, манай ард түмнээс хятадын ард түмэнд үзүүлж байсан сэтгэл харамгүй тусламжийг нэг биш удаа өндөр үнэлсэн юм. Тэн Дэхуай: «манай хятад, монгол хоёр улс бол ойр дотны хөрш, хоёр улсын ард түмний түүх нь уламжлалт найрамдлаар дүүрэн билээ. Монголын ард түмнээс хятадын хувьсгалд ах дүүгийн сэтгэл санааны дэмжлэг тусламж үзүүлснийг хятадын ард түмэн хэзээ ч мартаггүй. Хятадаас японы түрэмгийллийг эсэргүүцсэн дайны үед монголын ард түмэн, түүний арми, японы фашистын ихээхэн цэргийг өөрийн зүг татаж байсан бөгөөд 1945 оны 8-р сард баатарлаг монголын ардын цэрэг хүчирхэг Зөвлөлтийн армийн хамт манай улсын Зүүн Хойт районоор орж японы Квантуны цэргийг бутниргэж устгасан юм. Энэ нь японы эсрэг дайнд биднийг ялалт олоход гялалзсан сайхан хувь нэмэр болсон билээ. Монголын ард түмэн удаа дараа бидэнд тариалангийн морьд нийлүүлэн, манай улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн их үсрэнгүй хөгжилт, Тайвань арлыг чөлөөлөхийн тулд хийх тэмцэлд дэмжлэг үзүүлж байгаа билээ. Монголын ард түмний энэ эрхэм интернационалист үзлийг бид их бахдаж байдаг»<sup>7</sup> гэж тэмдэглэсэн байна.

Монголын ард түмэн Пэн Дэхуайг гүнээ хүндэтгэдгийн бэлгэ тэмдэг болгон түүнийг ардын цэргийн .. дугаар ангийн хүндэт байлдагч болгоход тэрээр «би үүрд танай ангийн хүндэт байлдагч больё»<sup>8</sup> гэж баярласан сэтгэлээ илэрхийлжээ. Пэн Дэхуайн энэ айлчлал монгол-хятадын ард түмний найрамдлын үйлсэд зохих хувь нэмрээ оруулсан нь дамжиггүй билээ.

Пэн дэхуай аливаа асуудалд намч, зарчимч ханддаг, намын сахилга батыг чанд сахидаг, эрс шийдэмгийгээрээ намынхаа дотор үлгэр дууриал болж байжээ. Тэрээр «шүүмжлэх хэрэгтэй хэмээн үзсэн бол дуугүй өнгөрдөггүй»<sup>9</sup> байсан тухай О. Браун бичсэн байна. Үнэхээр ч 50 иад оны эцсээр БНХАУ-д социализм байгуулахаар заасан ХКН-ын VIII их хурлын шийдвэрээс ухарсан «гурван улаан тугийн» бодлогыг Пэн Дэгуай шүүмжлэхгүй өнгөрч чадаагүй юм. Энэ ч түүний хувь заяаг эмгэнэлт байдалд хүргэсэн билээ.

1959 онд 7-р сарын эхээр ХКН-ын дээд удирдах ажилтны Лушаньд болсон зөвлөлгөөн дээр<sup>10</sup> Пэн Дэхуай шинэ «жанжин шугам», «Их үсрэлт», «ардын коммуны бодлого» улс ардын аж ахуйд хохирол учруулж, тус орны улс төрийн байдлыг хурцатгаж байна гэж шүүмжилсэн юм. Мөн 1959 оны 7-р сарын 14-нд Мао Зэдуны нэр дээр бичсэн захидалдаа «гурван улаан тугийн бодлогыг» жижиг хөрөнгөтний үзлийн илрэл, «зүүний алдаа» гэж нэрлээд, энэ бол «нэг далайлтаар коммунизмд орох» гэсэн оролдлого юм гэжээ. Лушаны зөвлөлгөөн дээр Пэн Дэхуайн хэлсэн үг, Маод бичсэн захидал нь ХКН-ын VIII их хурлаас (1956) баталсан БНХАУ-д социализм байгуулах чиг шугам, ХКН, Хятадын ард түмний эрх ашиг, тус орон дахь социализмын үйл хэргийг хамгаалахад

чиглэсэн юм. Энэ үйл явдлын үеэр мөн оны 8-р сард Лушаньд Мао Зэдуны зарлан хуралдуулсан ХКН-ын ТХ-ны VII бүгд хурлаар «Пэн Дэхуайн хэрэг» гэгчийг хэлэлцэн гаргасан тогтоолд намын эсрэг баруун оппортунист бүлэглэлийг» бутцоохих шийдвэр гаргажээ. Энэ нь түүхэн үнэн, шударга ёс, ард түмний эрх ашиг «агуу их» гэгдэгч удирдагчдын алдаатай шийдвэрт хэлмэгдсэний гунигт жишээ болсон юм.

Хөнөөлт «соёлын хувьсгалын» үед Пэн Дэхуайг зүйл бүрээр тамлан зовоож, 100 гаруй удаа зодож жанчсаныг түүний эхнэр Пу Аньсю хожим өгүүлсэн билээ.<sup>11</sup> Хэдий тийм боловч Пэн Дэхуай өөрийг нь мөрдөн мөшгөгчдөд «Би юунаас ч айхгүй. Би үнэний төлөө эрс хатуу зогсох болно»<sup>12</sup> гэж насан турш баримталсан үзэл бодлоо дахин давтан хэлж байлаа.

Харамсалтай нь, цаг үе улиран, түүхэн үнэн сэргэхийг Пэн Дэхуай үзэж чадаагүй юм.

1978 онд хуралдсан ХКН-ын ТХ-ны III бүгд хурлаар Пэн Дэхуайг цагаатгалаа. Нас барсанаас нь хойш бүтэн 4 жилийн дараа хийсэн гашуудлын цуглаан дээр Дэн Сяопин Пэн Дэхуайг: «ХКН-ын гайхамшигт гишүүн, ахмад үеийн пролетарийн хувьсгалч, дотоод гадаадад нэртэй цэрэг, улс төрийн зүтгэлтэн, манай нам, төр, армийн гарамгай удирдагч» гэж бодитойгоор үнэлээд «нөхөр Пэн Дэхуай нам, ард түмэндээ халуун хайртай, пролетарийн агуу их хувьсгалт үйл хэрэгт чин үнэнч байлаа»<sup>13</sup> гэж тэмдэглэжээ. Пэн Дэхуайн 1959 онд Мао Зэдунд бичсэн захиа «зөв байсан нь одоо тун тодорхой боллоо. Нөхөр Пэн Дэхуай алдаатай байр суурь баримтлаагүй, харин түүний эсрэг байсан хүмүүс л тийм байжээ»<sup>14</sup> гэж Жэньминь жибао» сонинд бичиж байв.

Орон нутгийн милитарист бүлэглэлийн жирийн цэргээс социалист хятад улсын цэргийн гарамгай зүтгэлтэн, маршал болтолоо Пэн Дэхуайн туулсан зам, саад бэрхшээлгүй байгаагүй ч марксизм ленинизмд үнэнч байж, ард түмнийхээ төлөө чин сэтгэл, шударга үйлсэд зориулсан тэмцлийн зам, үнэний зам байлаа.

1. Edgar Snow. Red Star Over China. N. Y 1961 p. 290-294
2. Пэн Дэхуай. Дурдатгалын хуудсууд. «Проблемы Дальнего Востока» сэтгүүл. 1987. № 4. с. 181-195
3. П. П. Владимиров. Хятадын онцгой район (1942—1945) УБ., 1975, 565-р тал
4. Чжун Цигуан. Пинзяны бослогын тухай дурдатгалаас «Цзефанцзюнь Вэньи» 1952 оны 12-р сар
5. «Жэньминь жибао» 1957. 8. 1
6. Отто Браун Хятадад хийсэн тэмдэглэл (1932—1939) УБ., 1979 87-р тал
7. «Улаан од» 1959. 6. 13
8. «Улаан од» 1959. 6. 6
9. О. Браун. Хятадад хийсэн тэмдэглэл (1932—1939) УБ. 1980. 87-р тал
10. Энэ тухай В. П. Фетов. Пэн Дэхуай, Душаньский пленум, «Культурная революция», «Проблемы Дальнего Востока», 1972. No 3. с. 129— 141-д
11. «Проблемы Дальнего Востока» сэтгүүл. 1987. № 4. 183-р тал
12. «Жэньминь жибао» 1984. 11. 26
13. «Жэньминь жибао» 1978. 12. 25
14. «Жэньминь жибао» 1979. 3. 8